

Ф.Ницше хүний тухай философидсон онцлог

Ц.Гомбосүрэн – МУИС.НШУС. Философийн тэнхмийн багш, профессор

Түлхүүр үг: Хүсэл. Хүсэл эрмэлзэл. Амьдрал. Аморализм. Хүний хэв маягууд. Үлэмж хүн. Заратустра. Дээд хүн. Хүчтэй хүн. Их хүн. Сул доройчууд. Илүүдлүүд. Хэрмэл сүүдэр. Буянтан. Сайн хүн. Хүүхэд. Эмэгтэй хүн. Сүүлчийн хүмүүс.

Оршил үг. Философийн бараг бүх сургаалын нэг чухал асуудал нь хүний тухай асуудал байдаг. Гэхдээ хүний тухай нэг ерөнхий тодорхойлолт боловсруулсан тийм философи сургаал байдаггүй билээ. Үүнийг нэн түрүүнд дараах хоёр шалтгааны үүднээс тайлбарлаж болох юм. Үүнд: нэгдүгээрт, хүн бол олон тооны сэтгэгчийн тэмдэглэж ирсэнчлэн нэн янз бүрийн (бие, сэтгэл, оюун зэрэг) талтай бөгөөд философичид тэдгээрийн аль нэгийг нь юм уу, зарим хэдийг нь онцолсны үндсэн дээр хүн гэж юу болох тухай тодорхойлж иржээ. Хоёрдугаарт, логикийн үүднээс авч үзвэл хүнийг ямар нэг (жишээ нь байгаль, бурхан тэнгэр, нийгэм гэх мэт) ерөнхий ойлголтонд хамруулах үндсэн дээр тодорхойлж болдоггүй (яагаад гэвэл өмнө дурьдсанчлан хүн болбоос нэн олон талтай байдаг тул тэдгээрийн аль нэг рүү нь оруулсан тодорхойлолт багтаамж, агуулга хоёрынхоо аль алины хувьд хүний гол гол шинж байдлыг бүрэн илэрхийлж чаддаггүй).

Тийм учраас философийн түүхэнд боловсруулж ирсэн хүний тухай тодорхойлолт багтаамж ба агуулгын хувьд нэн олон янз байж иржээ. Тэдгээр тодорхойлолтыг янз бүрийн үндэслэгээний үүднээс өөр өөрөөр бүлэглэж болдог. Жишээ нь, хүний тухай философи ойлголтуудыг анх үүсч, улмаар шинэчлэгдэж ирсэн түүхэн дарааллыг нь иш үндэс болговол: а/ сонгодог философийн; б/ сонгодог биш философийн; в/ постструктуралист болон модернист философидолтын хэмээн ангилж болох юм. Хэрвээ бодит байдлыг хэрхэн ойлгосныхоо үүднээс хүнийг философичид бас янз бүрээр тодорхойлснийг нь иш үндэс болговол дээрх ангилалд буй философи сургаалууд өөр логик бүлэглэлд багтах юм.

Бид энд сэдэвтээ холбогдохыг нь үндэс болгоод хүний тухай байгальчлагч ба нийгэмчлэгч үзлүүдийн талаар цөөн үг хэлье. Хүний тухай байгальчлагч, латинаар натуралист үзлийн хоёр хувилбар байдаг. Нэг нь хүнийг амьтантай адилтгаж, хүний амьтанлаг талыг дээдэлдэг үзэл юм. Энэ үзлийн үүднээс хүн ба нийгэм бол өндөр хөгжилтэй амьтдын үргэлжлэл ба дээд хэв маяг мөн. Тийм учраас хүн төрөлхтний амьдралд биологийн хуулиуд, тухайлбал, амьдралын төлөөний тэмцэл ба байгалийн шалгарал үйлчилдэг. Энэ нь улмаар "социаль-дарвинизм" нэртэй биологичлогч сургууль нийгмийн философид буюу онолын социологид бий болоход хүргэжээ.

Натуралист үзлийн нөгөө хувилбар нь хүн бол дутуу зэрэмдэг амьтан мөн гэдэг үзэл мөн. Жишээ нь, Ф.Ницшегийн томъёолсноор, хүн бол хүн дүрст бичнээс үлэмж хүн (over-man) рүү шилжих гүүр, дамжлага мөн. Түүний хувьд үлэмж хүн бол христос шашин, либерализм, социализм зэрэгт номолдог тэгшитгэгч, сүргийн ёс суртахууныг таягдан хаяад, зөвхөн Ганцаараа товойхыг зөвтгөгч шинэ ёс суртахууны үнэлэмжийг бүтээгч мөн.

Хүний үүсэл, мөн чанарыг нийгэмчилж тайлбарласан түүхэн зарим философи үзлийг энд бас онцолж дурдъя. Тийм үзлийн анхны томоохон төлөөлөгчдийн нэг нь Аристотель юм. Тэрээр хүнийг "полисын (хот улсын) амьтан мөн" гэж томъёолжээ. Тийнхүү тэрээр грекчүүдийн соёл ба иргэншлийг бусад ард түмнийхээс дээгүүр тавьдаг байр сууринаас хүн гэж юу болохыг тайлбарласан аж.

Хүний үүсэл, хөгжлийн шалтгааныг нийгэмчлэх (социологичлох) үзлийн үүднээс тайлбарлаж ирсэн нөлөө бүхий сургаалуудын өөр нэг нь марксизм мөн. К.Маркс бүр залуудаа уг үзлийг онолын үүднээс үндэслэхдээ: “хүний мөн чанар бол бодгаль тус тусад байдаг хийсвэр зүйл бус аа. Жинхэнэдээ тэрбээр нийгмийн харилцааны цогц мөн” гэсэн тухай марксист-ленинист онолчид ямагт өгүүлдэг билээ. Улмаар тэд ийм байр сууринаасаа хүний тухай бусад философи сургаалыг эрс шүүмжилж, өөрсдийн сургаалыг гүнзгийрүүлэн тайлбарлаж ирсэн юм.

Ф.Ницше хүний үүсэл, оршин тогтнолын түүхийг биологичлон тайлбарласны зэрэгцээ ирээдүйн хүний асуудлыг шинэ үнэлэмжтэй холбон тайлбарласан байдаг. Тийнхүү тэрээр ирээдүйн хүний асуудлыг шийдвэрлэхдээ нийгэмчлэгч үзлийн тодорхой хувилбарт үндэслэжээ.

Нэг. Ф.Ницшегийн хувьд хүн бол психик (сэтгэл),
ёс суртахуун хоёроор нөхцөлдөгч амьтан мөн.

Германы философич Ф. Ницше (1856-1900) хүн гэж юу болох, тэр нь үлэмж хүн буюу ирээдүйн хүнд хэрхэн шилжих тухай асуудлыг дэвшүүлээд, түүнийгээ өөрийнхөөрөө шийдвэрлэснээрээ философийн ертөнцөд нэр цуутай болсон билээ. Тэр шийдвэр нь психологизм, аморализм хоёрт үндэслэсэн байна. Ингэхдээ тэрээр психологизмыг натурализмын үүднээс, харин аморализмыг натурализм, социологизм хоёрын харилцан уялдаанд үндэслэн баримталсан гэж болмоор байдаг.

Психологизм бол Ф.Ницшегийн хувьд философийн нэн чухал арга зүйн үндэс мөнийг ганц баримтаар харуулъя. Тэрээр 1886 онд хэвлүүлсэн “Буян, нүгэл гэхгүйгээр” хэмээх зохиолдоо өмнөх бүтээлүүддээ өгүүлж ирсэн “хүсэл”, “хүсэл эрмэлзэл”, “ээрхэх хүсэл эрмэлзэл” гэсэн ойлголтуудынхаа агуулгыг тодотгосон байна.

“Хүсэл”, “хүсэл эрмэлзэл”, “амьдрал” гэдэг ойлголтууд бол Ф.Ницшегийн зөгнөж, улмаар өөрөө бүтээж эхэлж буй ирээдүйн философид чухал ач холбогдолтой. Энэ нь тэрээр хүсэл эрмэлзлийн тухай А.Шопенгауэрийн философи баримтлалд нилээд шүүмжлэлтэй хандаж, түүнийг “ард түмний төөрөгдөл” гэж үздэг болсны үр дүн байдаг. (Ф. Ницше. По ту сторону добра и зла. Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., 1990 с. 253-254) Тэрээр эдгээр ойлголтынхоо болон “ээрхэх хүсэл эрмэлзэл” гэдэг ойлголтынхоо агуулгыг “Буян нүгэл гэхгүйгээр” бүтээлдээ улам тодотгосон юм. Энд эхэлж онцлон дурдах ёстой сэдэв бол “хүсэл”, “хүсэл эрмэлзэл” гэдэг хоёр өөр ойлголтын тухай Ф.Ницше ярьсан нь юм.

“Хүсэл” гэдэг Ф.Ницшегийн ойлголт мэдрэмжийн зарим төлвийн нэгдлийг илэрхийлдэг аж. Ф.Ницше энэ тухай өөрөө бичихдээ: “аливаа хүсэлд нэгдүгээрт, олон мэдрэмж байдаг бөгөөд үүнд: бид ангижрахыг эрмэлздэг төлвийн тухай мэдрэмж, бид олж эзэмшихийг эрмэлздэг төлвийн тухай мэдрэмж, эдгээр эрмэлзлийн өөрсдийнх тухай мэдрэмж, дараа нь ба булчингийн дагалдагч мэдрэмж юм. Булчингийн мэдрэмж бол нэгэнт бид “хүсвээс” зарим төрлийн зуршлын хүчээр, бид “гар хөлөө” хөдөлгөхгүйгээр үүсдэг” (там же, с.254). Харин хүсэл эрмэлзэл бол хүслээс илүү нийлмэл бүтэцтэй. Түүнд сэрэл багтдаг төдийгүй бас сэтгэхүй ялангуяа цухалдал (аффект-Ц.Г.) нэмэгддэг (см. об этом: там же).

Ф.Ницше “Буян нүгэл гэхгүйгээр” зохиолдоо хүсэл, хүсэл эрмэлзэл хэмээх хоёр ойлголтыг тийнхүү зааглан үзсэн нь “ээрхэх хүсэл эрмэлзэл” гэдэг ойлголтын агуулгыг тэрээр тодруулахад нь чухал ач холбогдолтой болжээ. Үүнд: эээрхэх хүсэл эрмэлзэл бол нэг талаар тухайн амьд бие хүчээ илрүүлэхийг хүсдэг байдал, нөгөө талаар тэр бол амьдрал мөн. Амьдралыг “байнгын бүрэлдэл” мөн

гэж өмнө нь бичсэн байдаг Ф.Ницше яагаад түүнийг тийнхүү “эзэрхэх хүсэл эрмэлзэл” гэх болов оо.

Угтаа амьдралын тухай Ф.Ницшегийн энэ хоёр тодорхойлолт бие биеэ үгүйсгэдэг биш, харин ч харилцан бие биенээ сэлбэдэг гэж болох юм. Амьдралыг эзэрхэх хүсэл эрмэлзэл мөн гэж тодорхойлох нь биологийн мэдлэгт түшиглэх үндсэн дээр тухайн амьтны амьдрал бол аль нэг хүчинд тэр амьтан харьцахуй мөн гэж Ф.Ницше үзсэний үр дүн аж. Харин амьдралыг байнгын бүрэлдэл мөн гэж тэрээр тодорхойлдог нь хүний амьдрал бол мэдрэмж, сэтгэхүй хоёрын харилцан уялдаат үйл явцаар тодорхойлогддог хэмээн тэрээр онцолсон философи үзэл мөн.

Ф.Ницше 1888 онд хэвлүүлсэн “Христийн эсрэг үзэлтэн” гэдэг зохиолдоо “...юу сайн бэ? гэвэл хүн дэх эзэрхэх мэдрэмжийг, эзэрхэх хүсэл эрмэлзлийг, эзэрхлийг өөрийг нь нэмэгдүүлдэг бүхэн сайн мөн. Юу муу вэ? гэвэл сул доройгоос болж үүсдэг бүхэн муу мөн.

Аз жаргал гэж юу бэ? гэвэл лавширч буй эзэрхлээ мэдрэхүй, эсрэг үйлдлийг дийлснээ мэдрэхүй мөн. (Ф.Ницше. Антихрист, проклятие христианству.- Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., 1990, с. 633) гэж бичсэн байдаг.

Эзэрхэх хүсэл эрмэлзэл бол зөвхөн хүний биш, бас амьтан, түүгээр зогсохгүй ургамал гэх мэтээр аливаа амьд биеийн амьдралыг тодорхойлдог хэмээн Ф.Ницше үзсэн юм. Тэрээр эзэрхэх хүсэл эрмэлзлийг ургамалд хүртэл хамаатуулсан шалтгаан нь гэвэл Ф.Ницше эзэрхэхтэй холбогдуулан ярьдаг хүсэл эрмэлзэл (воля) бол жирийн хүсэл, тэмүүлэл, шунал биш, харин тушаагч цухалдал (аффект) байдаг. Сэтгэлийн тийм төлөв бол бие дааж байдаг биш, харин ямар нэг юманд хандсан байж, бүтээснээ өгч байдаг. Тийнхүү эзэрхэх хүсэл эрмэлзэл бол Амьдрал мөн. Улмаар Ф. Ницше эзэрхэх хүсэл эрмэлзэл үлэмж хүнд ямар онцлогтой байх талаар бясалгасан бөгөөд тэр тухай холбогдох газар нь авч үзэх болно.

Хүний тухай Ф.Ницшегийн философидолтын өөр нэг чухал онолын үндэс нь түүний боловсруулсан аморализм (ёс суртахууныг үгүйсгэгч үзэл) мөн.

Гэхдээ Ф.Ницшегийн аморализм ерөөсөө аливаа ёс суртахуунд холбогддог биш, харин христос шашин, либерализм, социализм зэрэг сургаалын ёс суртахууныг онилдог. Учир нь тэдгээр ёс суртахуун сул доройчуудыг, тэдний өширхлийг өөгшүүлдэг гэж Ф.Ницше үзжээ.

Ф.Ницшегийн анхан үеийн бүтээлүүдийн нэг болох “Хүмүүнлэг, хэтэрхий хүмүүнлэг” зохиолд нь: “ёс суртахууны мэдрэмжүүдийн түүх бол төөрөгдлийн түүх, үүнд өөрийн ээлжинд хүсэл эрмэлзлийн эрх чөлөө гэгч төөрөгдөл дээр тогтдог хариуцлага гэгч төөрөгдлийн түүх мөн” (Ф.Ницше. Человеческое, слишком человеческое. Книга для свободных умов.- Ф.Ницше. Сочинения в двух томах. Том 1. М.,1990 с. 267) гэсэн мөрүүд бий. Яагаад гэвэл хүн бол зайлшгүйн үр дагавар, өнгөрсөн ба өнөөгийн нөхцлүүдийн янз бүрийн элемент ба нөлөөний ургац тул оршихуйгаасаа ч, авир төрхөөсөө ч, үйл ажиллагаанаасаа ч хариуцлага хүлээх ёсгүй бөгөөд хариуцлага гэж ярих нь төөрөгдөл аж.

Ер нь Ф.Ницше мэдлэгийн аливаа төрлийг төөрөгдөл гэж үздэг билээ. Гэхдээ төөрөгдөл хүн төрөлхтний амьдралд зайлшгүй чухал байж чаддаг гэж тэрээр бас үзсэн юм.

Улмаар Ф.Ницше “Хүмүүнлэг, хэтэрхий хүмүүнлэг” зохиолдоо илэрхийлсэн шүүмжлэлт үзлээ энэ зохиолынхоо араас удалгүй цувуулан нийтлүүлсэн “Хэрмэл ба түүний сүүдэр”, “Үүрийн цолмон” гэдэг хоёр бүтээлдээ үргэлжлүүлсэн байна. Тухайлбал, тэрээр

“Хэрмэл ба түүний сүүдэр” зохиолынхоо 81 дэх афоризмд бичсэнээр христос шашны үүднээс аливаа хүний буруу үйлдэл бол энэ дэлхийн өмнө хийсэн гэмт.

хэрэг биш, харин бурхан тэнгэрийн өмнө хийсэн гэмт хэрэг мөн. Ийм учраас энэ дэлхийн утгат шударга ёсыг устгаж, дэлхийн шүүх ба ялыг үгүй болгож, оронд нь бурхан тэнгэрийн шүүх ба шийтгэлийг тогтоох ёстой юм. Ф.Ницше христос шашны ийм ёс суртахуунд захирагдмал бөгөөд энэ дэлхийд баримтлагддаг тийм шударга ёсыг үл зөвшөөрч байгаагаа илэрхийлж тэрхүү афоризмдаа "...хүн бүрт ямар ч хариуцлага, буруу оногдох ёсгүйн тухай сургаалын тусламжтайгаар энэ дэлхийн шударга ёсыг орвонгоор нь эргүүлж болно" (там же, с.820) гэсэн билээ. Тийнхүү тэрээр христос шашны номолдог ноёрхох, захирагдах ёс суртахуунд тааруулсан хариуцлага, шударга ёс зэргийг үл зөвшөөрсөн юм. Мөн христос шашны ёс суртахуунд зохицсон дотоод гэмшлийг үл тоомсорлож буй байр сууриа илэрхийлж, "Хэрмэл ба түүний сүүдэр" зохиолынхоо 38 дахь афоризмд "дотор гэмшил бол нохой чулууг мэрэх гэсэнтэй адил мангуурал мөн" (там же, с.817) гэсэн байна.

Германы энэ сэтгэгч бүр анхан үеийн бүтээлүүддээ тийнхүү христос шашны ёс суртахууныг тасралтгүй шүүмжилж ирсэн хэдий ч өөрөө нэлээд хожим, "Ессе Homo" зохиолдоо: ёс суртахууны эсрэг миний аян дайн "Үүрийн цолмон буюу ёс суртахууны балай зан заншлуудын тухай сэтгэлгээ" гэдэг номоор минь эхэлдэг гэж тэмдэглэсэн удаатай билээ (см. об этом: Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2, с.740). Тэрээр энэ номынхоо босгон дээр: "Хараахан гэрэлтээгүй буй олон үүрийн цолмон байдаг" гэсэн эртний Энэтхэгийн бичээсийг хадсан нь уг бүтээлийн зорилгыг тодотгож байдаг. Тодруулан дурдвал, Ф.Ницше шинэ өдрийн эхлэл болох бөгөөд одоогоор гэрэлтэн харагдахгүй байгаа тэр үүрийн цолмонг, сайхан өглөөг хаанаас олохоор эхэлсэн бэ? гэвэл зарим нэг үнэлэмжийг биш, харин **өнөөг хүртэл ноёрхож ирсэн бүх үнэлэмжийг хянан шинэчлэх** тийм үйл ажиллагаанаас эхлэх ёстой юм байна гэсэн эрс дүгнэлтэнд хүрснээ "Үүрийн цолмон..." зохиолдоо илэрхийлжээ. Ийм дүгнэлтэнд тэрээр хүрсэн шалтгаан нь түүний "Ессе Homo"-д илэрдэг. Үүнд: "хүн төрөлхтөн өөрийнхөө байгаагаар **зөв зам дагуу буй биш**, түүнийг удирддаг байдал бурхан тэнгэрлэг огтхон ч биш, харин ч эсрэгээр, үнэлэмжийн тухай хүн төрөлхтний ариун ойлголтуудынх нь дунд үгүйсгэл, гэмтлийн инстинкт, задралын инстинкт дур гутам ноёрхож байна" (там же, с.742) гэж Ф.Ницше үзсэнээс нь уг дүгнэлт үүдэлтэй гэж болохоор юм. Хүн төрөлхтний хувь заяаг гагцхүү Библи гэдэг ном л бурхан тэнгэрлэгээр гэгээрүүлэн жолоодож чадна хэмээдэг шашныхны шаардлага бол бодит байдлыг гуйвуулж, үнэнийг дарамталдаг хүсэл эрмэлзэл мөн гэж тэрээр эрс мэдэгдсэн байдаг (см. об этом: там же).

Өмнөх олон мянган жилийн уламжлалын үүднээс ёс суртахуунт хүн гэж хэнийг хэлэх талаархи үзлээ Ф.Ницше "Үүрийн цолмон..." номондоо илэрхийлсэн юм. Үүнд, түүний бичсэнээр "хуучин бүх цаг үеийн гол гол үндэслэл гэвэл ёс суртахуунлаг байдал бол тэдгээр нь ямар ч байдаг бай аливаа заншилд захирагдахуйгаас өөр юм (эсвэл илүү юм) биш ээ. Заншил бол янз бүрийн үйлдлийн уламжлалт арга мөн. Уламжлал тушаалаа буулгах газаргүй буй тийм нөхцөлд ёс суртахуунлаг байдал байдаггүй. Амьдрал уламжлалаар бага тодорхойлогдохын хэрээр ёс суртахуунлаг байдлын хүрээ хумигддаг" (Ф.Ницше. Утренняя заря, или мысль о моральных предрассудках.—Ф.Ницше. Сборник произведений. Мн., 1997, с.394). Тэгвэл уламжлал гэж юу вэ? гэвэл бидэнд ашиг тус өгөхгүй байлаа ч гэсэн буулгасан тушаалыг нь биелүүлдэг тийм дээд нэр хүнд бол уламжлал мөн (см. об этом: там же, с. 394-395). Тийм учраас уламжлал бол бодгаль хүний ашиг тусад нийцэх албагүй байж, биехүн өөрийгөө золиослоход бэлэн болгож байдаг. Чухам ийм утгаар ёс суртахуун бол заншлаар тодорхойлогддог гэж Ф.Ницше тайлбарласан юм.

Ёс суртахуунлаг байдлын тухай уламжлалт ойлголтын үүднээс хандвал хуулийг сахин биелүүлэх үйл ажиллагаа бол ёс суртахуунлаг байдлын өөр нэг

чухал үзүүлэлт гэж Ф.Ницше “Үүрийн цолмон...” зохиолдоо өгүүлжээ. Тэгэхдээ чухамхүү энэ үзүүлэлт бол хүний ёс суртахуунлаг байдлын тухай уламжлалт ойлголтонд гол ач холбогдолтой хэмээн тэрээр үзсэн нь уг зохиол дахь холбогдох үндэслэлүүдийн агуулгаас мэдэгддэг юм. “Ямар хүн хамгийн их ёс суртахуунлаг вэ? Нэгдүгээрт, хуулийг хамгийн тогтмол биелүүлдэг хүн мөн... Хоёрдугаарт, хамгийн хүнд нөхцөлд хуулийг биелүүлдэг хүн мөн. Хамгийн илүү ёс суртахуунлаг хүн бол заншлын төлөөнөө бүхнээс илүү золиослогддог хүн мөн” (там же, с. 395) гэж тэрээр бичжээ.

Ёс суртахуунлаг хүний тухай ийм хуучин ойлголтын үүднээс өнөөгийн бид маягийн хүмүүс хамгийн ёс суртахуунлаг биш байдлаар амьдрах боллоо. Учир нь гэвэл уламжлал, заншлын хүч суларсан гэж Ф.Ницше үзсэн билээ.

Европчуудын хувьд ёс суртахууны тухай хуучин ойлголтын уг сурвалж нь христос шашин мөн гэдэг дүгнэлтийг Ф.Ницше хийхдээ тийм ойлголтын нэг чухал илэрхийлэл болгож энэ шашин дахь энэрэх үзлийг шүүмжилсэн юм. Учир нь, “гагцхүү өр зөөлөн хүн л сайн хүн байж чадна” гэж христос шашинд номлодог нь хүний бодгаль сонирхлыг хөсөр орхиж, нийтийн ашиг хонжоог онцолдог байдал (см. об этом.: там же, с. 452-453) бөгөөд энэрэхүй бол сул доройг тэтгэж, ингэснээрээ зовлон төрүүлдэг (см. об этом: там же с,457) гэж Ф.Ницше эрс өгүүлсэн байдаг.

Улмаар Ф.Ницше уламжлалт ёс зүйн онол, зарчимд эсрэг олон үндэслэл дэвшүүлсэн нь хүний тухай түүний философи үзэлд онолын чухал үндэс болжээ. Тухайлбал, 1880-аад онуудын эхний хагас хугацаанд бичсэн олон зуун афоризмын эмхтгэл болох “Хорлонтой цэцэрхэл” номон дахь өч төчнөөн тооны өвөрмөц санаа нь ёс суртахууны сэтгэлгээнд шинэ шинэ хандлага оруулжээ. Зарим баримт дурдъя.

- Ёс суртахуун бол хүмүүс хоорондын харилцаагаар биш, харин хүн, байгаль хоёрын харилцаагаар нөхцөлдөн үүсдэг гэж Ф.Ницше үзсэн нь: “... ёс суртахуун бол байгалийн өмнө хүн таахалзахуй мөн” (Злая мудрость. Афоризмы и изречения. Ф.Ницше. Сочинения в двух томах. Том 1. М., 1990 с. 735) гэж тэрээр бичсэнээр илэрдэг.

- Хоёр өөр, бүр эсрэг тэсрэг ёс суртахуун байдаг тухай үзэл Ф.Ницшегийн үеийн философи сэтгэлгээнд шинэ биш боловч уг үзэлд тэрээр нэн чухал нэг шинэ хандлага оруулсан юм. Үүнд: “...дуулгавар”, “хууль” хоёр ёс суртахууны бүх мэдрэмжээс сонсогддог. Харин “дур зорго”, “эрх чөлөө” хоёр л ёс суртахууны эцсийн үг болж бас магадгүй юм. (там же с,736) хэмээн үзэж байгаагаа тэрээр илрэхийлсэн байдаг.

Тэгвэл хэний дур зорго, эрх чөлөөг Ф.Ницше ёс суртахууны үндэс болгосон хэрэг вэ? Ийм асуултанд хариулт болох үндэслэлүүд “Хорлонтой цэцэрхэл”-д буй. Үүнд: “... миний толгойд хувийн ёс суртахуунаас гадуур юу ч байдаггүй бөгөөд хувийн ёс суртахууныг өөртөө бүтээх эрх аваас ёс суртахууны тухай миний түүхчилсэн бүх асуудлын утга учир болдог” (там же) гэж Ф.Ницше дурдсан буй.

Тийнхүү Ф.Ницшегийн үзлээр хувийн ёс суртахуун бол ёс суртахууны нийтлэг хэм хэмжээнүүдийг хуульчлахын эсрэг хандлагатай. Чухамхүү хувийн ёс суртахууны ачаар дээд хүн бий болдог. Нөгөөтэйгүүр чухамхүү “...дээд хүний үйлдэл бүхэнд зан суртахууны хууль зуу дахин зөрчигддэг” (там же. “Дээд хүн” гэж Ф.Ницше ямар утгаар бичсэнийг бид хойно авч үзнэ).

Ф.Ницше ёс суртахуун (moral-мораль), зан суртахуун (morality-нравственность) гэдэг хоёр ойлголтыг зааглан авч үзсэн юм. Түүний хувьд ёс суртахуун бол боолын сэтгэлтнүүдийн буюу сүргийнхний үйлдлийг тэгшитгэх зарчимд нийцүүлэн зохицуулдаг. Харин зан суртахуун нь үлэмж хүний буюу хүчтэй хүний үйлдлийг Ганцаараагийн үйлдэл мөнийн нь хувьд зохицуулдаг.

Зан суртахуун бол үлэмж хүн бусдад саад учруулахгүйгээр эзэрхэх хүсэл эрмэлзлэлээ хангах сэтгэл зүйн гүн үндэс бүхий хэрэгсэл мөн.

Тийнхүү Ф.Ницше бол аморализмыг сурталчилсан биш, харин шинэ ёс суртахууныг, өөрийнх нь нэр томъёогоор хэлбэл зан суртахууныг номлогч мөн. Тэрээр сайн муу, нүгэл буяны ойлголтыг шоолдог нь сул доройчуудад тааруулан тэгшитгэхийг үл зөвшөөрдөг үлэмж хүний байр суурь байдаг. Сүргийнхэн, үлэмж хүн хоёрт ёс суртахууны тохироо байж болохгүй гэж тэрээр үзсэн байна.

Хоёр. Хүний тухай философидолтынх нь агуулга

Хүн гэж юу болохыг түүний аль нэг юм уу зарим хэдэн гол шинжийг нь онцлох замаар тайлбарладаг философи баримтлал олон байдаг тухай өмнө дурдсан билээ. Тухайлбал, хүний бие, сэтгэл, оюун гурвын аль нэгийг юм уу, тэдгээрийн нэгдлийг онцолдог, ингэхдээ хүний энэ гурван талыг өөр өөрийнхөөрөө тайлбарладаг философи сургаал философийн түүхийн бүх үеийн туршид гарч иржээ. Тэр бүгдийн дотор Ф.Ницшегийн холбогдох үзэл ихээхэн онцлогтой байдаг. Нэг баримт дурдъя. Хүн бол биетэйг философичид онцлохдоо хүний биологи талыг, хамгийн ерөнхийгөөр бол мэдрэгдэгч талыг нь тухайлж иржээ. Харин Ф.Ницше хүний биеийг өвөрмөцөөр тайлбарладаг байсан байна. Үүнд, тэрээр олон бүтээлдээ "бие" гэдэг үгээр мах цусан бодосыг биш, харин амьдралыг биежүүлэгч санааг тэмдэглэсэн байдаг юм. Жишээ нь: "Эзэрхэх хүсэл эрмэлзэл" гэдэг нэрээр хэвлэгдсэн, угтаа дуусгаж амжилгүй нас барсан зохиолдоо тэрээр: хүний бие бол бүх органик хөгжил дэх хамгийн алслагдсан зүйл, саяхны өнгөрсөн аль алиныг амьтай болгон, хэрэгжүүлж байдаг тийм санаа, тэхдээ хуучин "сэтгэлийг" бодвол илүү гайхашруулагч санаа мөн гэж тэмдэглэсэн байдаг. (см об этом напр. : Воля к власти. Опыт переоценки всех ценностей (1884-1888) с. 265). Тэгээд Ф.Ницше биеийн тухай яриа бол илүү дээд эрэмбийн санааны хөгжлийн тухай яриа мөн гэсэн билээ (там же, с. 274).

Хүний биеийг нь тийнхүү "сэтгэл" хэмээн онцолж буй юм чинь түүнийг (хүний) бусад талыг сэтгэлийн тодорхой хэв маяг мөн гэж Ф.Ницше үзсэн нь ойлгомжтой. Ер нь хүний олон хэв маягийг тэрээр өгүүлсэн нь сэтгэлийнх нь өвөрмөц хэв маягийн үүднээс тэр бүгдийг онцлон илэрхийлсэн байдал юм. Чухам тийм онцлолтуудыг нь тодруулан авч үзэхийг энэ өгүүллийн гол зорилго болголоо. Ийм зорилгоо хэрэгжүүлснийхээ үр дүнг одоо өгүүлье.

Хүн гэж юу болох тухай. Хүн гэж юу болох тухай философи ойлгоцоо 1883 онд хэвлүүлсэн "Заратустра ингэж өгүүлэв" зохиолдоо Ф.Ницше анх нэлээд тодорхой илэрхийлсэн юм. Уг зохиолд бичсэнээр (Так говорил Заратустра. Книга для всех и ни для кого.- Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., 1990. Часть первая) Заратустра 30 нас хүрэхдээ төрсөн нутаг усаа орхин, ууланд очиж, тэндээ сэтгэл зүрхээ чагнасан бясалгалыг 10 жилийн турш орь ганцаараа хийсэн аж. Тэгээд нэг өглөө сэрэхэд л сэтгэл нь өөрчлөгдсөн байж, улмаар уулнаас буугаад ойд орон, зарим адал явдалтай тааралдан байж, түүнээ туулаад хотод хүрч, наймааны захад олон хүн цугларсантай тааралджээ. Тэд бол олсон дээрх үзүүлбэрийг сонирхохоор цугларч хүлээж буй хүмүүс байв. Заратустра тэдэнд хандаж ийн өгүүлдэв:

"Би та нарт үлэмж хүний тухай сургаал хэлье. Хүн бол бид туулан давах ёстой зүйл мөн. Түүнийг туулахын тулд та нар юу хийсэн бэ?

Амьтны төрөл бүхэн өөрөөсөө дээш гарсан ямар нэг төрлийг хэдийн бий болгожээ. Гэтэл та нар хүнийг туулан давах нь бүү хэл энэ агуу давалгаанаас

зайлж, адгуусан байдалдаа бушуухан эргэж очихыг хүсч байна гэж үү?" (там же, с. 8) хэмээн цугларагчдыг зэмлэдэг.

Энд өгүүлж буй "үзүүлбэрийн олс" гэгчийг Заратустрагийн амаар "гүүр" хэмээн Ф.Ницше бас нэрлэн дурдсан юм. Тэрхүү дамжих олс буюу гүүрээр хүнийг Ф.Ницше зүйрлэн илэрхийлсэн байна. Үүнд: "...хүнтэй харьцуулахад сармагчин юу билээ? Инээдмийн амьтан, гутамшиг биз дээ. Үлэмж хүний хувьд хүн бас тийм инээдмийн амьтан, гутамшиг байх ёстой. Та нар өт хорхойноос хүн болох бүх замыг туулсан. Гэвч ихээхэн юм өтнөөс та нарт үлджээ. Урьд нэгэн цагт та нар сармагчин байсан. Гэхдээ хүн одоо ч гэсэн сармагчнаас илүү байж, үүгээрээ сармагчнаас ондоо юм" (там же, с.8).

Гэвч цугласан олон Заратустрагийн үгийг үл тоож, шоолон инээлдэж, Заратустра бас тэдний тийм байдлыг ойлгож ядан байв. Тэгээд тэрээр: хүн бол сармагчнаас /өөрөөсөө дутуу зэрэмдэг амьтнаас-Ц.Г./ үлэмж хүн рүү шилжих үзүүлбэрийн олс /канат/ шүү хэмээн нэмж хэлж байдаг. Өөрөөр хэлбэл, хүн бол бүх үнэлэмжийг хянан шинэчлэх үзэл санааны утгаар хэлбэл тэгж шилжих шаардлагын дагуу үхэхээс өөр замгүй буюу христосын ёсонд үндэслэдэг үнэлэмжүүдээ гээхгүй байх аргагүй тийм амьдралтан мөн.

Гэхдээ Ф.Ницшегийн үзлээр, хүн бол танигдашгүй онцлогтой бөгөөд харин тогтсон үнэлэмжийг халж, шинэ үнэлэмж бүтээгч нарыг ойлгож болно. Үүнд, түүний бичсэнээр Заратустра үгээ хэлж, олны доог болж байтал хоёр өндөр цамхагийн хооронд татаж, наймааны захын талбай, цугласан олон хоёрын дээгүүр татсан олсон дээр нэг бүжиглээч тоглолт хийж эхэлдэг. Цугласан олон, мөн Заратустра уг тоглолтыг үзэж байтал илүү чадварлаг алиа салбадай тэр олсоор дамжин элдэвлэхэд нөгөөх бүжиглэгч ялагдан самгардаж унаад, удалгүй үхдэг. Тэр үхдэлээс цугласан олон дайжиж тарахад гагцхүү Заратустра түүнийг оршуулахаа амьсгал хураахаас нь өмнө амжиж өөрт нь амлаж, түүнээ биелүүлдэг. Учир нь, Заратустрагийн үнэлэмжээр бол энэ үхдэл аюулыг мэддэг ч түүнээс айхгүйгээр олсон дээр бүжиглэхийг мэргэжлээ болгоод энэ мэргэжлээсээ болж үхдэг. Чухамхүү нэг цамхагаас нөгөө рүү, философи утгыг нь хэлбэл нэг үнэлэмжийн тогтолцооноос нөгөө рүү шилжих тийм хараал зүхэл идсэн эрсдэлтэй үйлдлийг зориг гарган хийж байгаад амь эрсдсэнийх нь төлөө Заратустра тэр үхдэлийг их чармайлт, хүч гарган хүндэтгэлтэйгээр оршуулдаг.

Тийнхүү Заратустра хүмүүст үлэмж хүний тухай хэлж өгсөн нь тэдэнд ойлгогдоогүй

/там же. с. 12/, өөрөө бас тэднийг ойлгоогүй /там же, с.15, 131-134/ билээ. Гэхдээ Заратустра амиараа дэнчин тавин олсон дээр бүжиглэгчийн үйлдлийг үнэнээр нь ойлгон мэдэж, тэрхүү бүжиглэгч ч гэсэн осолдон амь тавьж байхдаа Заратустрагийн хүндэтгэн тайвшруулсан үгэнд үхлийн зовуурь шаналлаа тэсэн байж талархал илэрхийлдэг /там же, с.13/. Тийм учраас Заратустра сэтгэлдээ: "... өнөөдөр Заратустра сайхан загасчиллаа. Тэрээр хүн барьж чадсангүй. Гэхдээ үхдэл дэгээдлээ. Хүний оршихуй аймшигтай, тэгээд бас марзагнал түүний хувь зохиол байж болох тул утга учиргүй юм.

Бүх хүмүүсийг ахуйнх нь утга учирт сургахсан. Энэ утга учир нь хүн хэмээх өтгөн үүлнээс цахилах аянга болох үлэмж хүн мөн. /там же, с. 14/ гэж бодож байдаг.

Ф.Ницшегийн дүрслэн бичсэнээр газар дэлхий бүрхүүлтэй бөгөөд тэр бүрхүүл олон өвчинд нэрвэгдсэний нэг нь "хүн" гэдэг нэртэй (см. об этом: там же, с.94). Тийм учраас "хүнийг яаж хадгалан хамгаалах вэ?" гэж биш, харин "хүнийг яаж давж гарах вэ? хэмээн асуух ёстой (см.об этом: там же, с.20).

Үлэмж хүн /over-man-сверхчеловек/ гэж хэн бэ?. Угтаа шидэт домог (миф), шашин, урлагийн бүтээл зэрэгт байгаль ёсны уг чанараараа нөхцөлдсөн амьдарлаа юманд үл бодон, түүнээ давж туулаад ариун дээд, аугаа төрөлтөн

болж хувирсан тийм үлэмж хүний тухай цөөнгүй өгүүлсэн байдаг билээ. Жишээ нь: шидэт домгийн үлэмж гавъяат баатрууд, уламжлалт нийгмүүдэд тэнгэр язгууртан болж алдаршсан хүмүүс, бурхан багш, Есүс, Мухаммед гэх мэт. Харин Ф.Ницшегийн философид тунхагладаг үлэмж хүн бол тэднээс өөр маягийн хүн мөн. Тэднээс ялгагдах түүний гол онцлогийг Ф.Ницше заасан юм. Үүнд: “үлэмж хүн бол газар дэлхийн утга учир юм” /там же/ гэж “Заратустра...”-даа тэрээр бичсэн байдаг. Ф.Ницшегийн олон бүтээл дэх холбогдох бичвэрүүдээс дүгнэн хэлэхэд, үлэмж хүн бол дээд тэнгэрээс заяат биш, харин хүн өөртөө байдаг байгаллаг амьдралаа дарамт, шорон мөний хувьд үл хайрлаж, харин өөрийнхөө иррациональ, инстинктив хүчнүүдийн ачаар эзэрхэх хүсэл эрмэлзэлтэн болох замаар өөрийгөө шинэчлэхүй мөн.

Ф.Ницше үлэмж хүнийг тийнхүү сэтгэл зүйн (психологийн) үүднээс тодорхойлсноос гадна түүний ёс зүйн онцлог ямар байхыг ямагт зааж иржээ. Үүнд, түүний тайлбараар үлэмж хүн бол үнэлэмжүүдийн тогтсон тогтолцоонуудыг голж, тэдгээрийг халаад улмаар шинэ үнэлэмжийн тогтолцоог бий болгон тээгч мөн.

“Заратустра”... болон бусад зохиолдоо Ф.Ницшегийн илэрхийлсэн тайлбараас францын философич Жиль Делёз 1965 онд хэвлүүлсэн “Ницше” гэдэг бүтээлдээ дүгнэлт хийхдээ: германы энэ сэтгэгчийн ярьж буй үлэмж хүн бол бататгаж болох бүгдийг **төлөврүүлсэн** хүн, байгаа бүхний дээд хэлбэр, сонгосон Ахуйн төрөлт ба субъектив эхлэл мөн гэсэн буй. Ж.Делёзийн эл дүгнэлтийг сонгодог (уламжлалт) философийн үүднээс ойлгох аргагүйг, жишээ нь энд дурдаж буй “сонгосон Ахуй” бол “матери”, туйлын санаа, “дээд ахуй” гэх маягийн ойлголтуудын нэг бишийг, тэр бол тухайн агшны бүрэлдлийн эзэрхэх хүсэл эрмэлзлийг илэрхийлсэн ойлголт мөнийг холбогдох туршлага суугаагүй уншигч нар ба судлаач нарт зориулан хэлэхэд илүүдэхгүй санагдаж байна.

Ж.Делёзийн ийм дүгнэлтийг зөвтгөх үндэслэгээ болсон философи үр дүн Ф.Ницшегийн бүтээлүүдэд арвин байдаг. Ялангуяа “Заратустра...” зохиолыг энд онцлоход тохиромжтой юм. Ф.Ницшегийн зохиолд гарч байгаагаар “Заратустра” гэж хэн бэ?

Угтаа “Заратустра” гэдэг нэр бол эртний Ираны шидэт домгийн баатрын нэр мөн. Гэхдээ судлаачид хр.т.ө. XII-X зууны хооронд Заратустра бодитой амьдарч, бүтээл туурвиж, зороастризмын шашныг үндэслэсэн гэж үздэг. (“зороастра” гэдэг нэр бол “заратустра” гэдэг үгний грек хэлбэр аж). Зороастризм бол эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, шидэт домгийн үзэл ба амьдралын хэв маягийг илэрхийлж үүссэн шашин ажээ. Тэр шашны үүднээс газар тариалан, суурин амьдралыг тэтгэгч Ахурамазда гэдэг тэнгэр бол дайнч нүүдэлчдийг тэтгэгч Ариман гэгч тэнгэртэй байнга тэмцэлддэг бөгөөд ирээдүйд Ахурамазда ялж, ингэснээр хүн төрөлхтөн нэг хэл, нэгдмэл төртэй болох аж. Эртний Грекийн зохиогч Дион Хрисост бичсэнээр Заратустра үнэнийг хайж аглаг ууланд даяанчлах болж, тэнгэрээс түүнийг галаар бүрхэхэд энэ даяанч шатаагүй төдийгүй харин ч гэгээрэн, цэцэн мэргэн болсон аж (Дорно дахины ард түмнүүдийн домогт гардаг Заратустрагийн тухай цухас боловч мэдээг миний олж уншсан бүтээлүүд: Н.И.Сидеронко. “Так говорил Заратустра” (Ницше). -Постмодернизм. Энциклопедия. Минск, 2001, с. 814; Мифы народов мира. Энциклопедия. 1 (А-К), с. 460-461; Краткий научно-атеистический словарь. М., 1964, с. 219-220).

Ф.Ницше өөрийнхөө философи туужийн гол баатарт шидэт домгийн баатрын нэр өгсөн нь тэр хоёрын үйлдлийн төсөөг иш үндэс болгосон бололтой. Үүнд, Ф.Ницшегийн зохиол дахь Заратустра бол үлэмж хүн биш, харин үлэмж хүнийг угтан хэлэгч, түүний төрөхөд нь туслагч мөн. Тэрээр

Заратустрагийн үг, үйлдлээр уламжлуулан нэг талаар үлэмж хүний чин эрмэлзлийг тунхаглах, нөгөө талаар “бүх үнэлэмжийг хянан шинэчлэх”-ийм хоёр ажиллагааг юуны өмнө ёс зүй, психологи, волонтаризмийн үүднээс, тэдгээрийн уялдаан дээр шийдвэртэй явуулжээ. Үлэмж хүний чин эрмэлзэл (идеал) бол хүн өөрийгөө бүтээх замаар тууштай эрх чөлөө эдэлдэг болж, ингэснээрээ хүн өөрийгөө соёлын хувьд төгөлдөржүүлэх нь ёс суртахууны гол үнэлэмж мөн гэдэг итгэл үнэмшлээ илэрхийлэх байдал мөн гэж “Заратустра ингэж өгүүлэв” гэдэг зохиолдоо Ф.Ницше сурталчилсан юм.

Үлэмж хүний олон чухал шинжийн тухай Ф.Ницше өгүүлжээ. Үүнд:

- Үлэмж хүн бол газар дэлхийн амьдралаас үндэстэй боловч жирийн хүнээс ангид байдаг гэж Ф.Ницше үздэг. Заратустра шавь нартаа хандаж сургахдаа: “... та нар өнөөдөр бүүр ганц ганцаараа байж, та нар холын холд амьдарч, хэзээ нэгэн цагт та нар ард түмэн болоорой. Чингэхүл өөрсдөө өөрийгөө сонгосон та нараас сонгомол ард түмэн, энэ ард түмнээс үлэмж хүн үүсэх ёстой. Үнэнээр нь хэлэхэд эрүүлжих орчин бол газар дэлхий бас байх ёстой” (Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2. М., 1990, с. 56) гэж байдаг.

Тийнхүү үлэмж хүн бол жирийн нэг хүн биш төдийгүй дээд хүн ч биш юм.

- Үлэмж хүн бол ард түмнээс хөндий, тасархай, ганцаараа байж, тийнхүү ганцаардмал байдаг нь бусадтай тэрсэлддэгээсээ урьд харин ч өөрийгөө эвдэж, өөрийгөө шинээр бүтээгчийнхээ хувьд өөртэйгөө тэрсэлддэгийнх нь шууд үр дагавар байдаг. “Чи бусдад гараа биш, харин сарвуугаа өгөх ёстой. Ингэхдээ сарвуу чинь хурц хумстай байгаасай билээ. Гэвч чамтай учирч болох хамгийн аюултай дайсан бол ямагт чи өөрөө байх болно. Чи өөрөө өөрийгөө янз бүрийн агуй ба аглаг ойд анана”(там же,с.46) гэж Заратустра өгүүлдэг.

- Үлэмж хүний амьдрал, үйл ажиллагааны эдгээр онцлог нь нигүүлсэл гэдгийг мэддэггүй ёс суртахуунтай байхад түүнийг хүргэдэг. “Нигүүлсэхээс илүү дээд оргилгүй тийм хайрлагч нар хөөрхийеэ... Би саяхан бас: “...хүмүүсийн төлөөх нигүүлслээсээ болж Бурхан тэнгэр үхсэн; Бурхан тэнгэр тэгж үхсэн шүү дээ” гэж чөтгөр ярьсныг сонссон” (там же,с. 64) гэж Заратустра өгүүлсэн удаатай.

- Нөр их шаргуу зан бол үлэмж хүний нэн чухал нэг чанар мөн (см. об этом: там же, с.115)

- Үлэмж хүн бол хошуучлагч (анхдагч) мөн.

- Үлэмж хүн бол золиосны хүн мөн. “Ах дүү нар минь, анхдагч хүн ямагт золиослогддог юм шүү. Иймд бид анхдагч нар мөн” (там же,с.144)

- Үлэмж хүний хайр бас чухал онцлогтой байх ёстой гэж Ф.Ницше сургамжилсан ажээ. Ингэхдээ тэрээр “Би”, “Чи” гэдэг хамаарлын (коммуникатив) ойлголтууд ашигладаг. Улмаар Ф.Ницше Заратустрагаар дараахь үгийг хэлүүлдэг. Үүнд, Заратустра: “ойрынхоо гэдэг та нарын хайр бол та нар өөрийгөө л гэдгээрээ дотор эвгүй оргиулдаг хайр мөн” (там же,с.43) гэж өгүүлдэг билээ. Заратустра ингэж хэлж байгаагийнхаа сэтгэл зүйн нэг шалтгааныг дурдахдаа: “... **Чи** бол **Би**-гээс ахмад. **Чи**-г ариун гэдэг бөгөөд гэхдээ **Би** биш юм. Үүнээс болоод хүн ойрынхондоо наалддаг” (там же) гэсэн юм.

Ойрынхоо биш, харин холынхныг, ирээдүйнхнийг хайрлаарай гэж Заратустра зөвлөдөг нь: “...бүх ойрынхон болон тэдний хөршүүд та нарт тэвчигдэшгүй болоосой. Тэр үед та нар бялхам сэтгэлтэй найз өөрөөсөө бүтээх ёстой доо” (там же,с. 44) хэмээн бэртэгчин сэтгэлээс ангид, өөрөөр хэлбэл үлэмж хүний араншинд нийцэх, тийнхүү бусдад уусдаг биш, харин бусдаас цойлох бололцоо олгодог хайрыг Ф.Ницше чухалчилдгийг илэрхийлдэг.

Тийнхүү үлэмж хүний хайр бол зөвхөн өнөөдрөөр амьсгалдаггүй, бусдын аянд авталгүй, бусдаар хайрлуулах гэж нойтогнодоггүй хайр юм. Энэ хайрыг

Ф.Ницше заримдаа “аугаа хайр” гэж нэрлэдэг. Олон түмний доторхи хүн ойрынхныгоо хайрлаж, тэр хайр нь хангалтгүй байдаг. “Хэрвээ тийм бишсэн бол өөрийгөө хайрлахгүй байна гэж бага уурлах байв. Аливаа аугаа хайр бол хайр бишийг хүсдэг. Үүнд, энэ хайр илүү чухлыг хүсдэг” (там же, с. 212) хэмээн Заратустра өгүүлдэг. Ф.Ницше хайрын тухай ийм үзлээ шударга ёсыг хангах чухал баталгаа гэж тооцжээ. Үүнд: “... чи ганцаардмал хүн тул хайрлах зам сонгожээ. Өөрөөр хэлбэл, чи өөрөө өөрийгөө хайрлаж, үүнийхээ улмаас зөвхөн хайрлаж чаддаг хүн басамжилдгийн адил чи өөрийгөө басамжилна... Хайрлаж чаддаг хүн басамжилдаг учраас тийм хүн бүтээх хүсэлтэй байдаг. Дүү минь чи өөрийнхөө хайр, бүтээх үйл хоёрын хамт аглаг нутаг руугаа яв. Зөвхөн ингэвэл л шударга ёс хойноос чинь харгалзан дагана” (там же, с.46).

Ийнхүү Ф.Ницше өөрийнхөө үедээ нөлөө бүхийгээр сурталчлан, амьдралд аажмаар хэрэгжүүлж байсан либераль ардчилалтай биш, харин үлэмж хүний үйлдэл, ёс суртахуунтай шударга ёсыг холбон үзжээ. Шударга ёсыг үлэмж хүнд холбогдуулан үзвэл (см. об этом: там же, с. 9, 45-46) тэр бол үлэмж хүний гал цог нь мөн. Үлэмж хүнд буян, нүгэл гэж байх шаардлагагүй аж. Учир нь Ф.Ницшегийн тайлбараар буян, нүглийн тухай ойлголт түгээмэл утгатай байдаггүй. Ийм баримтлал нь Ф.Ницше үлэмж хүнийг дээдэлж, түүнийг ганцаардмал, аглаг амьдралтай байхаас өөр аргагүй, өөрөөр хэлбэл олон түмнээс үлэмж хүн онцгойрч, тасархай байх ёстой гэж тэрээр үздэгтэй нь холбоотой байдаг. “Заратустра олон орныг, бас олон ард түмнийг мэдэж авч, төгснээрээ олон ард түмний буян нүгэл хоёртой тулгарав. Заратустра газар дэлхий дээр буян, нүгэл хоёроос илүү эзэрхийлэлтэй дайралдсангүй” (там же, с.41) хэмээн Ф.Ницше бичсэн юм. Гэхдээ “нүгэл” гэж тооцогддог үнэлэмж бол хүний сул биш, харин хүчтэй, сайн тал нь болж өгдөг гэсэн үзлийг Ф.Ницше илэрхийлсэн юм. Үүнд: “...“хүн нүгэлтэй” гэж бүх мэргэд надад тайтгаруулга болгон өгүүлсэн. Энэ нь өнөөдөр ч гэсэн бас үнэн гэгдэх вий дээ. Яагаад гэвэл нүгэл бол хүний шилдэг хүч мөн. “Хүн улам нүгэлтэй, шилдэг болох ёстой” гэж би сургадаг. Хамгийн их нүгэл бол үлэмж хүний шаардлаганд чухал” (там же, с.208) хэмээн Заратустра сургамжилсан байдаг.

Үлэмж хүнд буян, нүгэл хоёр хамаагүй, иймд энэ хоёрт захирагдах шаардлага байхгүй юм бол түүний (үлэмж хүний) үйлийг юу хөтлөх ёстой вэ? гэсэн асуулт гарч болох юм. Ф.Ницше тийм асуултын хариулт болох философи баримтлалыг бүр “Заратустра ингэж өгүүлэв” бүтээлээсээ өмнө боловсруулсан билээ. Тэр нь “эзэрхэх хүсэл эрмэлзлэл” гэдэг үзэл мөн. “Заратустра ингэж өгүүлэв” зохиолд: (см. об этом: там же, с. 82-83) амьдралыг бүтээгч хүсэл эрмэлзэл болох эзэрхэх хүсэл эрмэлзэл бол буян нүгэл хоёрыг төгсгөдөг. Амьд бие бүхэнд эзэрхэх хүсэл эрмэлзэл байдаг. Зарцын хүсэл эрмэлзэлд хүртэл өөрөөсөө сул доройгийн ноён нь болох санаархал байдаг. Том нь эзэрхэж баярлах гэхдээ жижгийг өөртөө үйлчлүүлдэг шигээ өөрийгөө бас эзэрхэх гээд өөрийгөө золиослодог. Золиос, үйлчилгээ, хайр байгаа газарт ноён болох гэсэн хүсэл эрмэлзэл байдаг гэж Ф.Ницше бичсэн юм.

Жирийн хүмүүсийн аз жаргал гэж үздэг зүйл бол үлэмж хүнд аз жаргал биш гэсэн санаа “Заратустра ингэж өгүүлэв” зохиолд бас байдаг. (см. об этом: там же, с. 9, 48, 114-117). Аз жаргал бол үлэмж хүний оршихуй нь зөвдөн батжихуй мөн гэж Ф.Ницше үзжээ.

Эрэлхэг зориг бол үлэмж хүний нэг чухал шинж болохыг Ф.Ницше дурдсан юм. “Айдаг, гэхдээ түүнээ ялдаг хүнд, ёроолгүй гүн хавцлыг харж байгаа, гэхдээ түүн рүү бардам өнгийдөг хүнд л эрэлхэг зориг байдаг. Гүн хавцал руу бүргэдийн нүдээр хардаг, гүн хавцлыг бүргэдийн сарвуугаар шүүрэн туулдаг тийм хүнд эрэлхэг зориг байдаг” (там же, с. 208). Үлэмж хүний хувьд үхэл нь

эртэдсэн ч биш оройтсон ч биш, харин цагаа олдог гэж Ф.Ницше сургамжилсан байдаг (см. об этом: там же, с. 32-33, 51-53).

Бойжсон эр хүн Тэгье гэдэг цагаа дууссан үед ариухан Үгүйг өгүүлээд үхье гэхдээ эрх чөлөөтэй, үхэж байхдаа ч эрх чөлөөтэй байдаг. Энэ бол үхэл, амьдралын тухай түүний ойлгоц мөн. Та үхэж байхад сэтгэл тань, буянт үйл тань бадарч байх ёстой. Тиймгүй байх аваас таны үхэл онцгүй байх болно гэж Заратустра өгүүлдэг.

Үлэмж хүн бол өрөвч сэтгэлтэн мөн. Үлэмж хүний өрөвч сэтгэл бол хүмүүсийг хайрласнаасаа болоод цовдлогдохоо тэвчин зөвшөөрөхүй мөн (см. об этом: там же, с. 9). Үлэмж хүн бол сайн үйлстэн мөн. Түүний сайн үйлс бол өөрийгөө буянтан гэх, бас нүгэлтэн гэх аль алинаас залхахуй мөн (см. об этом: там же). Үлэмж хүн бол шинэ үнэлэмжүүд бүтээгч мөн гэдэг санаа “Заратустра ингэж өгүүлэв” зохиолын бүх агуулгад, түүний баатруудын гол гол үйлдэлд шингэмэл байдаг.

Угтаа үнэлэмж бүтээх үйл бол зөвхөн үлэмж хүний биш, ер нь хүн төрөлхтний нийтлэг чадвар, гэхдээ ард түмэн бүрийн үнэлэмжийн тогтолцоо бие биеэсээ ялгаатай байдаг гэж Ф. Ницше үзсэн юм. Тэрээр ийм үзлээ Заратустрагийн дараахь үгнүүдээр илэрхийлсэн байна. Үүнд: “хүмүүс өөрийнхөө бүх буян, бүх нүглийг өөртөө өгчээ... Тэд түүнээ бусдаас аваагүй, замаас олоогүй байдаг... Хүн өөрийгөө авч үлдэхийн тулд эхлээд юмсад үнэлэмж оруулж өгдөг, өөрөөр хэлбэл тэр эхлээд юмсад утга, хүн төрөлхтний утга бүтээдэг. Тиймээс ч тэр өөрийгөө “хүн”, өөрөөр хэлбэл үнэлэгч гэж нэрлэдэг. Үнэлнэ гэдэг бол бүтээнэ гэсэн үг мөн... Үнэлэмжүүд солигдоно гэдэг бол бүтээгчүүд солигдож буй хэрэг. Бүтээгч байх ёстой хүн бол ямагт устгадаг.

Бүтээгч нар бол анхандаа янз бүрийн ард түмэн байсан бөгөөд гагцхүү хожим нь тус тус бие хүмүүс болсон юм. Үнэнээр нь хэлье, аль нэг бие хүн өөрөө бүтээлүүдийн, бас хамгийн залуу нь байдаг” (там же, с.42-43). “Аливаа ард түмэн өөрийгөө хадгалж үлдье гэж байгаа бол тэр нь эхлээд үнэлгээ хийхгүйгээр амьдарч чадахгүйсэн билээ. Тухайн ард түмэн хөрш шигээ үнэлгээ өгч болдоггүй. Нэг ард түмэн буян гэж нэрлэсэн олон юмыг өөр ард түмэн доромжлол, шившиг гэж нэрлэсэн байдгийг би мэдлээ” (там же, с.42) гэж Заратустра өгүүлдэг.

Үнэлэмжийн тухай Ф.Ницшегийн эдгээр өгүүлсэн зүйлс нь хүн төрөлхтөн амьдралыг бүтээх үйл явц бол танин мэдэхүйн ачаар биш, харин үнэлэмжийн ачаар, үнэлгээ өгсний үр дүн байдаг гэж тэрээр үздэгийнх нь чухал гэрч ба чухал нотолгоо мөн. Тийм учраас Ф.Ницше танин мэдэхүйн онолын асуудлыг зориуд авч үзэх зорилго тавилгүйгээр харин шаардагдсан зарим газарт уг онолын зарим холбогдох зүйлийг цухас дурдаж байжээ. Тухайлбал, үнэлэмжийг шинэчлэх үйл явцад танин мэдэхүй зохих ач холбогдолтойг, тэнд онолын өрсөлдөгч нь гаднаас дайсагнагч биш, харин бүтээгч, шинэчлэгч өөрөө өөртөө байдаг гэсэн үзлийг Ф.Ницше сурталчилсан юм.

Бурхан тэнгэр бол ер бусын, далдлаг, төгөлдөр хүчний утга мөн гэж Библид заадгийн эсрэг: үнэлэмж бол газар дэлхийн утга мөн гэж Ф.Ницше үзсэнийг бид ийнхүү бага зэрэг дэлгэрүүлэн тайбарлалаа. Тэндээс үзвэл үлэмж хүний тухай Ф.Ницшегийн баримтлал нь атеизмын өвөрмөц нэгэн хувилбарт үндэслэдэг аж. Тийм байр сууринаас шавь нартаа Заратустра захихдаа: “Миний дүү нар ...газар дэлхийдээ үнэнч үлдээрэй. Та нарын өгөөмөр хайр, та нарын танин мэдэхүй тань газар дэлхийн утгад үйлчлэх болтугай” (там же, с. 55) гэдэг.

Урьд бол бурхан тэнгэрийг муулах нь хамгийн муу үйл байв. Гэвч бурхан тэнгэр үхэж, ингэснээр муулагчид ч үхэв. Одоо бол газар дэлхийг муулах нь хэзээ ч ухаарагдашгүйгийн мөн чанарыг газар дэлхийн утга учраас илүүд үзсэн

тийм хамгийн аймшигт гэмт хэрэг юм" (там же, с. 8) гэж "Заратустра" зохиолд байдаг.

Ф.Ницшегийн хувьд "үлэмж хүн" гэдэг ойлголт бол "Бурхан тэнгэр" гэдэг ойлголтыг сөргүүлэн гаргаж ирсэн философи ойлголт юм. "Бурхан тэнгэр үхлээ. Одоо бол үлэмж хүн амьдраасай гэж бид хүсэж байна" (там же, с. 207) хэмээн Заратустра өгүүлдэг. Тийм учраас хүн бол гүүр ахул, харин үлэмж хүн бол зорилго мөн гэж Заратустрагийн үгээр дамжуулж Ф.Ницше онолоо сурталчилсан байдаг.

Сул доройчуудыг Ф.Ницше ангилсан нь. Ф.Ницше үлэмж хүний ёс суртахууны үнэлэмжийн үүднээс түүнтэй харьцуулахад эрэмдэг, сул доройчуудыг тэдний сэтгэл зүйн болон ёс суртахууны харилцан уялдаат онцлогийнх нь үүднээс хэд хэдэн бүлэгт хуваагаад тэдгээрийг дорд үнэлэн шүүмжилсэн юм. Тухайлбал:

Нэг. Дээд хүмүүс. Тэд олон байдаг. Дээд хүмүүс бол бурхан тэнгэрийг нас барсны дараа бурхан тэнгэрлэг үнэлэмжүүдийг хүн төрөлхтний үнэлэмжүүдээр сольдог, өөрөөр хэлбэл шинийг бүтээгч тийм хүмүүс мөн. Үүгээрээ үлэмж хүнтэй төсөөтэй байдаг. Гэвч дээд хүмүүс бол газар дэлхийгээс гадны Бурхан тэнгэрийг үгүйсгэдэг боловч газар дэлхийн тодорхой зүйлийг, тухайлбал илжгийг Бурхан тэнгэр болгон өргөмжилдөг тийм хүмүүс мөн (см. об этом напр.: там же, с. 224-226). Тийнхүү дээд хүмүүсийн шинэ бүтээл бол ер бусын далдлаг зүйлийг биш, харин байгалийн зүйлийг Бурхан тэнгэр болгодог тийм бүтээл юм. Гэхдээ тэд бол Заратустраг шоолдог, харин угтаа алиа салбадайд (Заратустраг хонзогногч, шоологчид) ойр байдаг хүмүүс мөн.

Ф.Ницше дараах маягийн дээд хүмүүсийг онцолсон. Үүнд:

1. Сүүлчийн пап лам. Энэ бол Бурхан тэнгэр үхсэн гэдгийг мэддэг, гэхдээ Бурхан тэнгэр аваас байнгын нигүүлсэх сэтгэлээсээ болж дотроо багтран, хүмүүст хайраа цаашид өгөх тэнхэлгүй болсон гэж боддог хүн юм.

2. Хоёр ноён. Эд нар бол "сайхан сэтгэлийн" үйлдлийн төлөөлөл мөн. Уг үйлдлийн зорилго нь хүнийг төлөвшүүлэн өсгөх, эрх чөлөөтэй болгоход оршдог. Үүнийхээ тулд хамгийн хатуу ширүүн хэрэгслийг ч гэсэн ашигладаг. Ийм учраас хоёр ноён байгаа. Нэг нь зүүн буюу хэрэгслийн ноён, нөгөө нь баруун буюу зорилгын ноён аж. Энэ хоёр ноён дүүрэн ачаатай илжиг тууж явдаг. Тэр илжгийг нь дээд хүмүүс шинэ бурхан тэнгэрээ болгосон.

3. Хамгийн жигшүүрт хүн. Энэ бол бурхан тэнгэрийн нигүүлслийг үл тэвчсэндээ түүнийг алсан хүн. Гэхдээ хамгийн жигшүүрт хүн бол бас л урьдын хүн, бүр түүнээс ч муу хүн. Учир нь, өөрийнхөө төлөө үхсэн Бурхан тэнгэрийг юманд үл бодон, хүнийг нигүүлсэхийг, түүний дотор харц хүнийг нигүүлсэхийг Бурхан тэнгэр урьтал болгодог нь хамгийн жигшүүрт хүний тэвчээрийг бардаг. Чухамхүү хамгийн жигшүүрт хүн л илжгэнд залбирч мөргөхөд дээд хүмүүсийг түлхдэг.

4. Хувалзан хүн. Энэ бол бурхан тэнгэрлэг үнэлэмж, шашин зэргийг, түүгээр зогсохгүй ёс суртахууныг танин мэдэхүйгээр орлуулахыг хүсдэг хүн мөн. Хувалзан хүн бол хамгийн өчүүхэн юмны маш нарийвчилсан мэдлэгийг эрхэмлэж, тийм мэдлэгээр "айхтар" бүрхэг үнэлэмжид бид бишрэхийг оруулдаг хүн юм. Угтаа танин мэдэхүй бол хувалз юм; танин мэдэхүй бол амьдралыг чичилж, амьдралыг бэртээж, адалж ирсэн ёс суртахуун, шашны пайзыг өөртөө шилжүүлж авсан юм гэдгийг хувалзан хүн мэддэггүй.

5. Сайн дурын гуйранч. Энэ хүн бол танин мэдэхүйгээс ч татгалзагч, аз жаргалаас өөр юманд үл итгэгч хүн. Сайн дурын гуйранч бол аз жаргалыг Бурхан тэнгэрээс биш, харин газар дэлхийгээс хайдаг. Гэхдээ тэр нь ямар ч балай хүнд боловч жаргал өгдөг тийм юм байх ёстой. Өш хонзон, буруу

гэмшилд автсан харц хүнд аз жаргал байдаггүй. Хүн төрөлхтөн аз жаргалаа үхрээс олно гэж сайн дурын гуйранч үздэг.

6. Элдэвлэгч. Бурхан тэнгэрийн эзэгнэлийн үед ч, Түүний үхсэнээс хойш ч буруугаа гэмшигч болж маяглагч хүн. Элдэвлэгч бол Ариадна ч болж, яруу найрагч юм уу атеист ч болж жүжиглэгч мөн. Худалч. Аашлахын донтон. "Энэ миний буруу" гэдэг элдэвлэгчийн үг нь өөрийгөө өрөвдөн хайрлуулах, хүчитнүүдийг буруутан гэж итгүүлэх, амьтан бүгдийг ичээх, өөрийн хороор бүгдийг хордуулах зэрэг зорилготой байдаг.

7. Хэрмэл сүүдэр. Энэ бол Бурхан тэнгэр эзэгнэж буй үед, түүний үхсэний дараа, танин мэдэхүйд, аз жаргалтай үед зэрэг хэзээ л бол хэзээ, хаана л бол хаана зорилготой байдаг соёлын үйл ажиллагаа мөн. Гэхдээ зорилгодоо хэзээ ч хүрдэггүй. Учир нь, түүний зорилго бол Заратустрагийнх бөгөөд Заратустраг цаг ямагт, газар сайгүй дагаж, зөвхөн өөрчлөлтийн аугаа их цагууд болох үд дунд, шөнө дунд хоёрт л алга болдог.

8. Төлөгч. Энэ бол нигилизмийн сүүлчийн шатыг угтан мэдээлэгч мөн. Уг төлөгч нь хүн Бурхан тэнгэрийг байранд нь тавих гэсэн чармайлтаа бүтэхгүйг мэдэхлээрээ юу ч үгүйг гэх хүсэл эрмэлзлийг биш, харин хүсэл эрмэлзлийн юу ч үгүйг сонгодог тийм цагийг угтан мэдээлэхүй байдаг. Тийнхүү төлөгч бол сүүлчийн хүнийг зөгнөдөг. Тэрээр нигилизмийн төгсгөлийг зөгнөдгөөрөө дээд хүмүүсээс цааш явдаг. Гэвч мөхлийг хүсдэг хүн болох сүүлчийн хүний замд байдаг зүйл нь Төлөгчөөс мултардаг. Дээд хүмүүсийн ийм төлөөллүүдийг Ф.Ницше онцолсон аж.

Хоёр. Их хүн. Их хүн гэж юу болох тухай Ф.Ницшегийн үзэл Заратустрагийн дараах үгэнд илэрдэг. Үүнд: "...хэрвээ хамгийн шилдэг юмсыг хэн ч дэвшүүлээгүй бол тэр юм үнэ цэнэгүй байдаг. Эдгээр дэвшүүлэгч хүмүүсийг ард түмэн их хүмүүс гэж нэрлэдэг" (там же, с.37). Тийнхүү их хүмүүс бол бас л бүтээгч (дэвшүүлэгч) мөний хувьд үлэмж хүнтэй төсөөтэй юм. Гэхдээ их хүн бол үлэмж хүн бишээ. Учир нь, ард түмэн бол ямар нэг аргаар алдар нэртэй болсон хүмүүсийг, тийнхүү элдэвлэн жүжиглэгчдийг ч их хүн гэж үздэг. Эндээс үзвэл их хүмүүс бол ард түмэнд ойр байж, найз нөхөд нь болдог хүмүүс мөн.

Гурав. Илүүдэл хүмүүс. Ф.Ницше мальтусч үзлийн үүднээс төрийн үүслийг адлан тайлбарладаг. "Дэндүү олон хүн төржээ. Тиймээс илүүдлийн төлөөнөө төр бүтээгджээ. Тэднийг, энэхүү олон олонлогийг төр өөртөө хэрхэн татдагийг хараарай. Төр тэднийг яаж хянаж, айлгаж, хэвдэг гээ!" (там же) хэмээн Заратустра халагладаг. Ф.Ницше "илүүдлүүд" гээд буй тэр хүмүүс бол либераль үзэлтнүүд, ардчиллын төлөө тэмцэгчид мөн. Тэдний хувьд төр бол шинэ шүтээн болсон. Тиймээс тэдэнд Заратустра хандан: "... хуучин бурхан тэнгэрийг ялагч та нар аа, төр та нарыг ч гэсэн тааварладаг болсон. Та нар тэмцэлд ядарч, одоо та нарын ядаргаа шинэ шүтээнд үйлчилнэ!" (там же) гэж байдаг.

Төр төгсөж буй тийм газарт илүүдэл биш хүн шинээр гарч ирдэг гэж Ф.Ницше тэмдэглэсэн нь ардчиллыг, ардчилсан төрийг устгаад, оронд нь үлэмж хүний эзэрхлийг тогтоох гэсэн түүний хүсэл эрмэлзлэлийнх нь илэрхийлэл юм (см. об этом: там же, с.37).

Ф.Ницше "Заратустра ингэж өгүүлэв" зохиолоо бичсэнээсээ хойш ч гэсэн хүний тухай философи асуудлыг зарим бүтээлдээ хөндсөн байна. Тухайлбал, 1888 онд хэвлүүлсэн "Шүтээний бүдэгрээн буюу лантуугаар хэрхэн философиддог вэ?" гэдэг бүтээлдээ уг асуудлыг хөндсөн юм. Тэр бүтээлд сул доройчууд, хүчтэй хүмүүс хоёрын ялгааг дарвинизмын эсрэг байр сууринаас тайлбарласан байдаг. Үүнд (см. об этом: Ф.Ницше. Сумерки идиолов, или как философствуют молотом.- Ф.Ницше. Сочинения в двух томах. Том 2, М., 1992, с. 601), Ф.Ницшегийн үзлээр дарвинизм дахь "амьдралын төлөөний тэмцэл"

бол нотолгоо байхаасаа урьд өгүүлэхүйн үр мөн нь давамгай юм. Амьдралын төлөөний тэмцэл байдаг ч тэр нь тохиолдол байдаг. Амьдралын ерөнхий илрэл бол гачигдал биш, өлсгөлөн биш, харин баян, хангалуун байдал, түүгээр зогсохгүй утгагүй үрэлгэн байдал мөн. Тиймээс тэмцэл гарах нь эзэрхлийн төлөө байдаг. Тэмцэлд хүчтэнгүүд биш, харин сул доройчууд ялаад ноёд болдог. Яагаад гэвэл сул доройчууд тоогоороо олон, бас илүү ухаалаг байдаг. Харин сул доройчууд нь илүү ухаалаг байдгийг Дарвин ойлгоогүй (Ф.Ницше "ухаан" гэдэгт болгоомж, тэвчээр, заль, дүр эсгэх, биеэ айхтар эзэмдэх зэргийг ойлгодог). Гэтэл хүчтэнгүүдэд тийм ухаан үл шаардагдаж, тэд төрөлх байгаагаараа байдаг.

Улмаар Ф.Ницше суут (аугаа) хүмүүс гэж хэн байдаг, тэр нь яаж төрдөг тухай бодлоо илэрхийлсэн юм. Үүнд (см. об этом: там же, с. 618-619): аугаа хүмүүс бол аугаа цаг үеийн адилаар асар их хүч хуримтлуулсан бодис мөн. Хэрвээ олон түмний бухимдал үнэхээр бургилж байвал амьдралд "суутныг" төрүүлэх тийм тохиолдлын цочроогч аяндаа бий болж байдаг. Аугаа хүмүүс төрөх цаг хугацаа тохиолдол байж, харин тэд зайлшгүй байдаг. Аугаа хүмүүс бол өөрийг нь ноёрхдог хүмүүсийн бүтээл мөн. Яагаад гэвэл ноёрхогч хүмүүс бол аугаа хүмүүсээс илүү хүчтэй, ахмад, аугаа хүмүүсийг төрүүлэхийн төлөө байдаг. Аугаа хүн бол төгсгөл мөн. Аугаа их цаг хугацаа, жишээ нь сэргэн мандал бол төгсгөл мөн. Суут хүн бол бүтээлээрээ, үйл хэргээрээ суут болдог. Өөрийгөө хамгаалах инстинкт суут хүнээс холддог. Тэр бол өөрийгөө хамгаалах инстинктээ дараад биеэ үл хайрлан золиосолж, өөрийгөө бусдад зориулдаг.

Ф.Ницше хүчтэй хүний тухай ойлгоцынхоо үүднээс гэмт хэрэгтэнг үнэлсэн юм. Үүнд (там же, с.619-620) гэмт хэрэгтэн бол хүчтэй хүний нэг хэв маяг, гэхдээ олиггүй нөхцөлд эмгэгтэй бүтсэн хүчтэй хүн мөн. Ийм хэв маягийн хүчтэй хүн аваас ахуйн илүү эрх чөлөөт, илүү эрсдэлт уг чанар ба хэлбэрийг тооцох нь дутаж, инстинктийнх нь зэвсэг, хамгаалалт хоёр болдог тэр бүхэн нь хууль цааз байдаг. Гэмт хэрэгтний буянг нийгэм авч үздэггүй. Түүний хамгийн амьдлаг инстинктүүд нь дарангуйлагч цухалдал, сэжиглэл, айдас, нэр төргүй байх зэрэгтэй авцалддаг. Энэ бүгдээс болоод төрөхөөсөө хүчтэй, нийгмээсээ хүчтэй хүн гэмт хэрэгтэн болдог. Ариун Елена аралд цөлөгдсөн Наполеон үүний нэг барин тавин жишээ мөн.

Ф.Ницше бас дуусгаж амжилгүй нас барсан суурь бүтээлтэй бөгөөд түүнийг нь орос хэлэнд "Эзэрхэх хүсэл эрмэлзэл" гэдэг нэрээр 1995 онд хэвлүүлжээ. Уг бүтээлд хүний тухай хоёр чухал сэдэв байдгийг энд өгүүлье.

Буянтан. Ф.Ницше: итгэл, хүндэтгэл, үнэн рүү тэмүүлэх, сэтгэл татагдах, намчирхахгүй ("объективист") байх, үнэнч байх, тэвчээр, нэр төр зэрэг сүргийн ёс суртахууны эрхэм чухал шинжүүд буянт хүнд байдаг хэмээн тоочоод, харин тэдгээр нь угтаа залхуурлын илэрлүүд мөн хэмээн дурджээ (см. об этом: Ф. Ницше. Воля к власти. М., 1995, с. 106).

Ф.Ницше сүргийн ёс суртахуунд өргөмжилдөг буянтны эсрэг өөрийн дэвшүүлсэн зан суртахууны үзэлд нийцсэн буянтныг сөргүүлэн тавьжээ. Тийм шинжилгээний үр дүнг "Буянтны ноёрхлыг хэрхэн хангах ёстой вэ?" гэдэг гарчиг бүхий хэсэгтээ илтгэсэн юм. Тэнд бичсэнээс дүгнэлт хийхэд Ф.Ницшегийн хувьд буянтан бол хүн өөрийгөө өөртөө зориулсны үр дүн байдаг. Харин сүргийн моралистуудын (ёс суртахууны сургаалтнуудын) хувьд буянтан бол хүн өөрийгөө бусдад зориулсны үр дүн байдаг.

Ф.Ницшегийнхээр буянтны гол онцлог нь ховор, дуураймал биш, онцгой, ердийн биш зэрэг язгууртанлаг байдал юм. Иймд түүнийхээр буянтан бол дундаж хүнд байдаггүй олон инстинкттэй, оюун ухаанлаг тал багатай бөгөөд харин адгуу, тусгаар оршигч, ашиг хонжооч биш, хэвшмэл зорилгогүй, дэг журам ба түүний аливаа хэлбэрт агуулагддаг худал хуурмагт дайсагнангүй,

бусдад учруулдаг хор уршиг ихтэй зэрэг шинж бүхий (өөрөөр хэлбэл сүргийн ёс суртахуунд дээдэлдэг буянтанд байдаггүй олон шинж бүхий) юм.

Өөрийнхөө дэвшүүлсэн зан суртахуунд тохирох буянт хүнийг таних дараахь хэдэн шалгуурыг Ф.Ницше онцолдог. Үүнд: 1) өөрийнгөө таниулах гэж эрмэлздэггүй; 2) буянтнуудад биш, харин өөр ямар нэг зүйлд санаа тавьдаг; 3) буянтан байхгүйгээс болж хохирдоггүй бөгөөд ер нь бусад руу нийлж нэгддэггүй; 4) суртал ухуулга гээд байдаггүй; 5) буянтан ямагт өөртөө буянтан мөн тул өөрийгөө буруутгахыг хэнд ч зөвшөөрдөггүй; 6) буянтан бол ер нь чухамхүү хориглодог бүхнийг үйлддэг бөгөөд өөрөөр хэлбэл буянтан бол аливаа сүргийн хууль тогтоомж дахь хориотон мөн. Ф.Ницше эдгээр санаагаа дүгнээд: буянтан бол Сэргэн мандалтын буянтны маягтай, ёс суртахуундахаас чөлөөлөгддөг буянтан мөн гэж тэмдэглэсэн байдаг (см. об этом: там же, с 122).

Харин сүргийн ёс суртахуунд эрхэмлэдэг буянтан бол нэгж байх ёсгүй бөгөөд түүнд тэгш хүн олон байж, түүнд зөвхөн өөрт нь оногддог үнэлэмж гэж байдаггүй хэмээн Ф.Ницше үзсэн юм. Яагаад гэвэл ийм маягийн буянтнууд бол хүнийг загварчилсан ерөнхий схемд нийцдэг ажээ. Ийм буянтнууд бол хүний гологдол мөн төдийгүй аюултай. Тодруулан хэлбэл тэд бол нэр хүнд ба хуулийн утгаар биднийг гаднаас маань эзэрхэцгээдэг гэж Ф.Ницше үздэг байжээ.

Сайн хүн. Сайхан сэтгэл, нэр төр, үүргээ мэдрэхүй, шударга ёс, хүмүүнлэг ёс, үнэ хүнд, шулуун ил зан, үнэхээр хэрсүү зан зэрэг гоё үгнүүд амьдралд дангаараа үнэхээр байж, тэдгээрийг эзэмшсэн бөгөөд харин тэдгээрийн эсрэг муу чанар бүхнээс ангид байж чаддаг тийм “сайн хүн” байдаг тухай ёс суртахууны янз бүрийн номлол бол бүгд худал хуурмаг мөн хэмээн Ф.Ницше үзсэн юм (см. об этом напр.: там же, с. 137-139). Ийм сургаалуудын зарим нь Библийн агуулгад үндэслэж “сайн хүний” тухай ёс суртахууны баримтлалыг туйлд нь хүргэдэг гэсэн санааг тэрээр нэмэн илэрхийлжээ.

Ф.Ницше “сайн хүн” гэдэг ёс суртахууны ойлголтын агуулгыг “худал” хэмээн үндэслэхдээ: энэ ойлголт мууг үгүйсгэж, зөвхөн сайн бие, сайн хүн байж болох мэт сурталчилдаг нь угтаа “сайн”, “муу” хоёр харилцан бие биенээ нөхцөлдүүлж байдгийг үл харгалзсан байдал мөн гэжээ. Тэгээд тэрээр: мууг бүрэн устгаад, сайныг ганцаар нь үлдээх ёстойн тухай үзэл бол хэрэг дээрээ амьдралын эсрэг үзэл мөн гэж тэмдэглэжээ.

Тийнхүү “сайн хүн” гэдэг сүргийн ёс суртахууны ойлголт бол амьдралын хэрэгсэл биш, харин амьдралын зорилгыг заагч утгатай, өөрөөр хэлбэл үнэнч, шударга хүн бол муу бүхнээс татгалзан ангижирсан сайн хүн болж чадахыг заагч утгатай байдаг хэмээн Ф.Ницше шүүмжилсэн юм. Тэгээд тэрээр уг ойлголт дараахь хэдэн функцийг хүн төрөлхтний амьдралд гүйцэтгэснийг онцлон тэмдэглэсэн байдаг. Үүнд:

-“Сайн хүн” гэдэг ойлголт бол дарангуйлагч мөн. Энэ ойлголтыг баримталснаар хүн төрөлхтний тодорхой зарим төрөл (жишээ нь эгэл ард түмэн, арьстан) нь бусад харгалзах төрлүүдтэйгээ адил тэгш эрхтэй хэмээн тунхаглахад хүрч, ингэснээр уг төрөл нь ноёрхох хүсэл эрмэлзлээсээ татгалзаж, энэ нь эцсийн эцэст түүнийг (уг төрлийг) мөхөөхөд хүргэнэ.

-Сайн хүнийг тунхагладаг нь хэрэг дээрээ үлгэр жишээ (идеал) боол төлөвшүүлэх тунхаг, тодруулан хэлбэл өөрийгөө “зорилго” хэмээн сэтгэхийн оронд өөрийгөө золиослох ёс суртахуун руу аяндаа, инстинктив байдлаар хэлбийгч тийм хүнийг төлөвшүүлэх ёстой гэдэг утга бүхий байдаг.

-Сайн хүний тухай ойлголт бол эцсийн эцэст Бурхан тэнгэрийг, Есүсийг дээдлэх бишрэлийн үндэстэй юм. Ийнхүү сайн хүний тухай ойлголт бол эзэрхэг хүсэл эрмэлзлийг үгүйсгэж, иймд амьдралд эсрэг янз бүрийн үзэлд ёс суртахууны үндэс нь болдог хэмээн Ф.Ницше үзжээ. Тийм ч учраас тэрээр:

“сайн хүмүүс бол тэд муу байхад чухал хангалттай биш хүчтэй учраас сайн байдаг хэмээн Латука Коморро аймгийн удирдагч Бакеру хэлсэн юм. ...Зөөлөн сэтгэл жаргалгүй байдаг хэмээн оросууд ярьдаг” (там же, с.138) гэх мэтээр дурдсан биз ээ.

Ф.Ницше өөрийнхөө бүтээлүүдэд хүн, түүний өөр өөр хэв маягийн бие хүнийг сэтгэл зүй, ёс суртахууны харилцан уялдаат онцлогийнх нь үүднээс шинжилснийг бид авч үзлээ. Үүний сацуу тэрээр хүн төрөлхтний танин мэдэхүйн болон үнэлэмжийн зарим үр дүнг хүний тодорхой зарим төлөөлөлтэй жишин адилтгажээ. Ийм зүйрлэл нь тэдгээр төлөөлөл тус бүрийн сэтгэл зүй, ёс суртахууны онцлогийг дашрамдаа илэрхийлсэн хүн судлалын ач холбогдолтой. Ялангуяа хоёр төлөөллийг Ф.Ницше онцолжээ. Үүнд:

1. Хүүхэд. Энэ бол шинэ үнэлэмжийг бүтээгч сэтгэл мөн. “Заратустра ингэж хэлэв” зохиол дахь “Эрдэмтдийн тухай” гэдэг өгүүлийг О.Чимэг орчуулан нийтлүүлснээс “хүүхдийг” хөндсөн хэсгийг нь энд иш татъя. “Намайг унтаж байх хооронд толгой дээр байсан ороонго өвсөн титмийг минь хонь хэвж эхэлсэн бөгөөд тэр хэвэнгээ: “Заратустра эрдэмтэн байхаа больжээ” гэж хэлэн байв.

Үүнийг хэлээд тэрээр хажуу тийш ихэрхүү бардам янзтай зайлав. Энэ тухай надад хүүхэд хэлсэн юм.

Би энд, хүүхэд тоглодог газар, нурсан хананы дагуух зараа уул, улаан намуу цэцгийн дунд хэвтэх дуртай байдаг юм.

Хүүхдүүдийн хувьд, бас зараа уул, улаан намуу цэцгийн хувьд би эрдэмтэн хэвээр байсаар. Тэд хонзогнохдоо хүртэл гэнэн гэмгүй билээ.

Харин хонинуудын хувьд бол би эрдэмтэн байхаа нэгэнт больжээ: хувь заяа минь үүнийг хүсэж байгаа юм-тэр адистэд хүртэх болтугай!

Учир нь үнэндээ би эрдэмтдийн орон гэрээс явж, хаалгаа ч хойноосоо хав хийтэл хаасан юм.” (Эрх чөлөө ба философи. Философи нийгмийн сэтгэлгээний бүтээлийн цуврал эмхэтгэл. VI. УБ., 2000, 33-34 дэх тал).

Одоо энэ иш татсанахаа агуулгыг нь (Ф.Ницшегийн философидолтын ёж хэллэгийн утгыг тооцон) илэрхийлэх оролдлого хийе. Үүнд, Ф.Ницше хуучинсаг, хоцрогдсон, тэгээд бас бэртэгчин эрдэмтэн нарын сэтгэлд үл хүрч, тэдэнд элдвээр муу хэлүүлэх болжээ. Энэ нь Ф.Ницше үнэлэмжийг хянан шинэчлэх үйл ажиллагаа явуулдаг болсноос шалтгаантай аж. Гэлээ ч гэсэн тэрээр хуучин сэтгэлгээг нэвтэлж буй шинэ үнэлэмжид үнэнч байж, улмаар шинэ үнэлэмжийг онолын үүднээс боловсруулах ажлыг эргэлт буцалтгүй явуулах болсон юм. Шинэ үнэлэмж, энэ талаархи онолын үйл ажиллагаа учир дутагдал гаргалаа ч гэсэн ач холбогдлоо гээдэггүй гэж Ф.Ницше үзсэн юм.

Харин хуучин үнэлэмж, хуучин сэтгэлгээг Ф.Ницше нэг нүдээрээ ч харахаа больсон юм. Тэр бол ирээдүйн философич, ирээдүйг зөгнөгч мөн. Тийнхүү Ф.Ницше шинэ үнэлэмжийг хүүхэдтэй зүйрлэсэн нь хүүхэд бол өөрийнхөөрөө байдаг тийм шулуун шударга зантай, ирээдүй хойч мөн байх хувь заяа бүхийг нь иш үндэс болгодог гэж болохоор юм. Ф.Ницше “... над руу ирэх бололцоог тохиолдолд олго. Учир нь, тэр бол бага хүүхэд лугаа адил буруугүй” хэмээн бодлоо илэрхийлсэн байдгийг энд нэмж дурдъя (Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2, с. 125).

2. Эмэгтэй хүн. Харин Ф.Ницше эмэгтэй хүнд одоогийн нэр томъёогоор хэлбэл антифеминист байрнаас хандсан нь түүний зохиолуудад илэрдэг. Энэ нь эмэгтэй хүнтэй түүний холбогдсон зарим томоохон тохиолдол бүтэлгүйтсэнтэй нь зарим сэтгэл зүйн хувьд холбоотой байж болох юм (гэхдээ Ф.Ницшегийн намтар дахь зарим мэдээнээс хийж буй миний эл бодол хөнгөдсөн байж магадгүй).

Феминист үзлийн үүднээс хандвал таагүй сэтгэгдэл гарцаагүй төрүүлэх мөрүүд “Заратустра ингэж өгүүлэв” зохиолд бий. Заратустра нөхрийн тухай

өгүүлэхдээ: "...эмэгтэй хүний дотор боол, тарчлаагч хоёр хэт удаан нуугджээ. Тийм учраас эмэгтэй хүн нөхөрлөх ч чадваргүй, тэр зөвхөн хайрлахыг мэддэг бөлгөө. Хайрладаггүй бүхэндээ шударга биш, тоомжиргүй ханддаг байдал эмэгтэй хүний хайранд байдаг. Гэхдээ эмэгтэй хүний хэвшмэл хайранд ч гэсэн бас цочмог сэтгэл ч, аянга цахилгаан ч, гэрэлтэй зэрэгцсэн харанхуй ч ямагт байдаг. Эмэгтэй хүн нөхөрлөх чадвартай хараахан биш. Учир нь, эмэгтэйчүүд муур, шувуу хэвээрээ л байна. Эсвэл сайндаа үнээнүүд юм" (там же, с.41) хэмээн эмэгтэй хүнийг хавчуулан, түүнд хувийн үнэлгээгээ өгч байдаг.

Энд Ф.Ницше эмэгтэй хүнийг биш, харин сэтгэлийн идэвхигүй, өрөөсгөл хүсэмжлэгч, үүний хамт зовлон учруулагч, итгэл алдуулагч чанарыг ярьсан байх үндэстэй. Гэхдээ тийм буй тохиолдолд ч гэсэн сэтгэлийн тийм өрөөсгөл, хөнгөмсөг, тогтворгүй байдлыг эмэгтэй хүнээр төлөөлүүлэн ярих нь давхартаа эмэгтэй хүнийг хөндсөн байхаас зайлахааргүй санагдаж байна.

Ийм дүгнэлтийн үндэслэгээ болж чадах нэг зүйл дурдахад тэрээр танин мэдэхүйн онолд "үнэн" гэж нэрлэдэг ойлголтыг "эмэгтэй хүн" гэж нэрлэжээ. Нэгэн эмгэн Заратустрад хандан хэлэхдээ: "Заратустра цөөн эмэгтэй мэддэг ч гэсэн тэдэнд зөв ханддаг. Энэ нь эмэгтэй хүнд бололцоогүй юм гэж юу ч байдаггүйгээс биш үү?

Харин одоо талархлын бяцхан үнэн аваарай. Би тийм үнэнд илт хөгшдөөд байна" (там же, с. 48) гэж байна. Энэхүү ишлэлийн утгыг танин мэдэхүйн онолын үүднээс тайлъя гэвэл Ф.Ницше философид хэвшмэл байдаг үнэний тухай сургаалуудад ач холбогдол бага өгдөг бөгөөд гэхдээ энэ нь тэдгээрт зүйтэй хандлага бүхий юм. Яагаад гэвэл үнэн гэгддэг мэдлэг ямагт наана цаана эргэлзээнд оруулж байдаг. Ф.Ницше үнэний тухай асуудалд хандахдаа цоо шинэ байр сууринд шилжсэн байна.

"Заратустра ингэж өгүүлэв" зохиолд "Хөгшин, залуу хүүхнүүдийн тухай" гэдэг гарчиг бүхий өгүүлэл байдаг. Тэнд эмэгтэй хүнийг эр хүнээс доогуур тавьдаг үзэл нь тод илэрсэн юм. Үүнд: "...эмэгтэй хүнд байгаа бүхэн нь оньсого бөгөөд эмэгтэй хүнд байгаа бүхэн нь ганц тайлалтай нь жирэмслэлт мөн. Эмэгтэй хүний хувьд эрэгтэй хүн бол хэрэгсэл мөн. Зорилго нь ямагт хүүхэд олох байдаг. Тэгвэл эрэгтэй хүний хувьд эмэгтэй хүн чухам юу юм бэ? Жинхэнэ эр хүн хоёр юм хүсдэг нь аюул осол, тоглоом хоёр мөн. Тийм учраас тэрээр эмэгтэй хүнийг хамгийн аюултай тоглоом мөний хувьд хүсдэг. Эрэгтэй хүн дайтах, эмэгтэй хүн дайчныг цэнгүүлэх хүмүүжилтэй болох ёстой... Эмэгтэй хүн дурласан үед эрэгтэй хүн түүнээс айж байдаг. Учир нь дурласан эмэгтэй юу ч хийхээс буцдаггүй бөгөөд дурлалаас бусад юм ямар ч үнэ цэнэгүй болдог... Ер нь эмэгтэй хүн нэр төрийг маруухан ойлгодог. Эрэгтэй хүний жаргал: би хүсэж байна гэдэг нэртэй. Эмэгтэй хүний жаргал: тэр эрэгтэй хүсэж байна гэдэг нэртэй" (там же, с. 47-48) гэж Заратустра өгүүлдэг. Товчоор хэлбэл, эмэгтэй хүн гүехэн, харин эрэгтэй хүн гүн бодолтой гэсэн үзлийг Ф.Ницше илэрхийлжээ.

Гэхдээ Ф.Ницше эмэгтэй хүнийг ийнхүү шүүмжлэхийн зэрэгцээ түүний ирээдүйд өөдрөгөөр хандсан юм. Үүнд (см. об этом напр.: там же, с. 47-48):

- Эмэгтэй хүн хүүхдийг эрэгтэй хүнээс илүү ойлгодог;
- Жинхэнэ эр хүн дотор тоглох дуртай хүүхэд нуугдаж байдаг тул эмэгтэйчүүд түүнийг нь олдог байтугай;
- Эмэгтэй хүн хараахан бий болоогүй ертөнцийн (буянт үйлсээрээ гялалзагч) очир эрдэнэ мэт гялалзагч гэрэлт, тунгалаг тоглоом болог;
- Эмэгтэйчүүдийн хайранд од гялалзаг;
- "Үлэмж хүнийг төрүүлэхсэн" гэдэг мөрөөдөлд эмэгтэйчүүд автаг;
- Эмэгтэйчүүдийн хайранд эр зориг байг;
- Хайранд нь нэр төр байг хэмээн Заратустра ерөөл тавьдаг.

Эмэгтэй хүнд хандах Ф.Ницшегийн өөдрөг үзэл нь “Аз жаргал миний хойноос хөөж байна. Энэ нь би эмэгтэйчүүдийн хойноос гүйгээгүйгээс юм. Аз жаргал бол эмэгтэй хүн шүү дээ” гэж Заратустра бодолд автдагт бас илэрдэг.

Резюме

В данной статье её автором делается анализ философских положений немецкого философа Фридриха Ницше (1844-1900), относящихся к проблемам человека. Статью пронизывает такая мысль, что если в различных направлениях классической философии, существовавших при жизни Ф.Ницше человек рассматривались как единство тела, души и ума или некоторых из них, то в философии Ф.Ницше он (человек) рассматривается как тесное единство его психических и моральных сторон.

Ном зүй

- Ф. Ницше. Сочинения в двух томах. Том 2, М., 1990
- Ф. Ницше. Воля к власти. М., 1995
- Постмодернизм. Энциклопедия. Минск, 2001.
- “Эрх чөлөө ба философи”- Философи нийгмийн сэтгэлгээний бүтээлийн цуврал эмхэтгэл. VI. УБ., 2000,